

Наркологийн эмнэлэг

1972 онд Сэтгэл мэдрэлийн больницод "Архины тасаг" байгуулагдсанаар Наркологийн эмнэлгийн анхны суурь тавигдсан түүхтэй. МУ-ын Засгийн газрын 1994 оны 175 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 1994.10.14-ний өдрийн А/185 тоот захирамж гарч уг тасгийг 75 ор бүхий "Архинд донтох өвчтөнийг албадан эмчлэх эмнэлэг" болгон зохион байгуулж 1994 оны 10 дугаар сарын 20 ноос эхлэн явуулж эхэлсэн байна.

Шүүхийн шийдвэрээр албадан эмчлүүлэх этгээд, өөрийн сайн дураар эмчилгээ хийлгэх хүсэлтэй өвчтөнүүд гэх аль ч талаараа өөр хоорондоо эрс ялгаатай хүмүүсийг хүчээр нэг доор бөөгнөрүүлэн/ эмчилж байсан шинжлэх ухаанч бус үйл ажиллагаа байсан нь амьдралын шалгарлаар нэгэнт нотлогджээ.

Эмнэлгийн ерөнхий эмчээр Сэтгэц наркологийн эмч, клиникийн профессор Ш.Бат-пүрэв 1994-1999 он хүртэл ажиллаж байв. Л.Эрдэнэбаяр 1999-2000 он хүртэл ерөнхий эмчээр ажиллаж байв. Дээрх зохион байгуулалтыг нэн даруй өөрчлөх шаардлагатайг НЭМГ-н шинэ удирдлага дүгнээд НИТХ-ын 1999 оны 10/44 тоот тогтоол болон Нийслэлийн Засаг даргын 1999 оны А/ 229 дүгээр захирамжаар "Архинд донтох өвчнийг албадан эмчлэх" эмчилгээний тасгийг Бага-хангай дүүрэгт шилжүүлж, Нийслэлийн Засаг даргын 1999 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/246 тоот захирамжаар "Архинд донтох өвчнийг эмчлэх" сайн дурын эмчилгээний тасгийг нь өргөтгөн "Наркологийн Эмнэлэг" болгон өөрчлөн зохион байгуулж, Анагаах Ухааны магистр, клиник профессор, докторант Сэтгэц мэдрэл, наркологийн эмч Х.Хулан 2000 оны 12 сарын 15-нас ерөнхий эмчээр томилсон тэрээр өнөөг хүртэл ажиллаж байна.

Эмнэлгийн үйл ажиллагаа

Наркологийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шинэчлэл 1997-1999 он

Архинд донтох өвчнийг албадан/ сайн дураараа эмчлүүлэгчид зориулсан цөөн тооны ортой/ эмчлэх эмнэлэг байсныг өөрчлөн 1999-2003 он

Сайн дураараа эмчилгээнд хандсан, архи болон бусад мансууруулах бодист донтсон өвчтөнийг эмчлэх 2003-2004

Архинд болон бусад мансууруулах бодист донтсон өвчтөнийг эмчлэх 2003-2004

Архинд болон бусад мансууруулах бодист донтох өвчин архины солиорол архины хүнд, хурц хордлогыг эмчлэх 2004 он

Эрчимт эмчилгээний блокийг архины хүнд хурц хордлогоос өвчтөнийг гаргах орчин үеийн тоног төхөөрөмж бүхий байдлаар шинэчлэн байгуулав.

Пара-клиник үйл ажиллагаа:

2001 оноос

Орчин үеийн тоног төхөөрөмж бүхий эмнэлгийн лабораторийг байгуулан жилээс жилд шинэ тоног төхөөрөмж аппарат, хэрэгслээр өргөтгөн үйл ажиллагааг явуулж байна.

2002 оноос Сэтгэл судлалын кабинетыг

- Эмгэг сэтгэл судлалын кабинетыг
- Бүлгийн сэтгэл засал хийх
- Эмчилгээнд өвчтөний өөрийн оролцооны арга зүйн дэвтэр хөтлүүлэх
- Реабилитаци эмчилгээ хийх үйл ажиллагаа зохион байгуулан ажиллуулж эхлэв.

Удирдлага менежментийн үйл ажиллагаа:

2001 он Эмнэлгийн гадаад дотоод орчныг тохижуулах үйл ажиллагаанд гол анхаарал хандуулан ажиллаж, эмчлүүлэгч-сэд таатай орчин бий болов.

2002 оноос Наркологийн эмнэлгийн үйл ажиллагааны хэтийн болон нэн ойрын жилүүдэд стратеги төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллаж эхлэв.

Наркологийн төрөлжсөн нарийн мэргэжлийн стационарын бүтэц үйл ажиллагааны стандартыг боловсруулсан мөрдөж байна.

Архинд донтох өвчин, архины хүнд хордлогуудын оношлог оо эмчилгээний стандартыг боловсруулан мөрдөж ажиллаж эхлэв.

Тус эмнэлэг нь нийт 29 ажилтантай

Их эмч 4, сэтгэл зүйч 1, сувилагч 5, асрагч 6, бусад ажилтан 13, үүнээс тэргүүлэх зэргийн их эмч 1 магистр 2, клиникийн профессор 1, бакалавр зэрэгтэй сувилагч 1 ажиллаж байна.